



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар

А/224

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагаа”-ны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1.Удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т;

2.2.Удирдамжийг суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтын оролцоонд суурилан ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд үр дүнтэй хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

2.3.Үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжүүлэхэд харьяа нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.4.Удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай хариу арга хэмжээ авах, явц, үр дүнг хагас жил тутам Боловсролын ерөнхий газарт тайлагнаж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /У.Өлзийцэцэг/-т үүрэг болгосугай.

САЙД



П.НАРАНБАЯР

Боловсролын сайдын 2025 оны 15 дугаар
сарын 14-ны өдрийн 15 дугаар
тушаалын хавсралт

“СУРГУУЛИЙН СОЁЛ-СУРАЛЦАГЧИЙН ТӨЛӨВШЛИЙГ ДЭМЖИХ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

АТА12937 9116621 9024070582

Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд суралцагчийн харилцаа, хандлага, ёс зүй, хамт олонч байдал, бие даах чадвар, хариуцлагатай байх зэрэг хувь хүний төлөвшлийн асуудал нийгмийн анхаарлын төвд өргөн хүрээтэй яригдах болсон.

Сургууль бол суралцагчийн өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг бөгөөд хүүхдүүд үе тэнгийнхэн болон багш нараа өөрийнх нь дэмжигч, туслагч хэмээн хүлээн зөвшөөрч тэнд өнгөрүүлж байгаа цаг хугацаа нь тэдний ирээдүйн хөгжилд чухал болохыг хүлээн зөвшөөрдөг.

“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйл” үндэсний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 27,2 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчин (сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цуглардаг газар)-д аюулгүй байдал алдагдсан, 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэж хариулт өгсөн байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд сургуулийн орчинд суралцагчдын сэтгэлзүйн болон бие махбодын аюулгүй байдал алдагдах эрсдэл байсаар байгаа нь сургуулийн соёлыг төлөвшүүлэх, орчныг сайжруулах шаардлагатай болохыг харуулж байна.

Өнөө үед суралцагчийн зан төлөв, хүмүүжил нь зөвхөн гэр бүл төдийгүй сургуулийн орчин, харилцаа, хамт олны уур амьсгалтай холбоотой. Энэ утгаар сургуулийн соёл нь суралцагч, багш, ажилтны харилцаа, хандлага, хамтран ажиллах уур амьсгалаар дамжин илрэх бөгөөд энэ нь суралцагчийн хөгжил, хүмүүжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Сургуулийн соёл гэдэг бол сургуулийн удирдлага, багш, сурагч, хамт олны нэгдмэл итгэл үнэмшил, үзэл санаа, үнэт зүйл, бахархал, хандлага хэмээх далд орших чанарууд, түүний тусгал болон ил орших билэгдэл, дадал зуршил, хэм хэмжээ, дүрэм журам, сахилга бат, эмх цэгцийг илтгэсэн цогц тогтолцоо юм (Ж.Галбадрах Ph.D, 2016)

Сургуулийн эерэг соёл нь суралцагчдын ёс зүй, хариуцлага, бусдыг хүндлэх хандлага, бие даан хөгжих чадварыг төлөвшүүлэх суурь болдог. Мөн багш, суралцагч, эцэг эхийн хоорондын харилцаанд итгэлцэл, ойлголцол бий болгож, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэн, сургалтын үр дүнд сайнаар нөлөөлдөг.

Сайн төлөвшсөн сургуулийн соёл нь суралцагчийн хувь хүний хөгжлийг урт хугацаанд дэмжиж, ирээдүйн ажил амьдрал, нийгмийн харилцаанд шаардлагатай чадвар, зөв хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд ч чиглэдэг байна.

Иймд сургуулийн соёлыг төлөвшүүлэх нь зөвхөн байгууллагын өнгө төрхийг илэрхийлэх бус суралцагчийн хүмүүжил, төлөвшил, хөгжлийг цогцоор дэмжих үндсэн хүчин зүйл болж байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан боловсролын сургалтын байгууллагын онцлогт нийцсэн, сургуулийн соёлын тодорхой элементүүдийг төлөвлөх,

суралцагчийн төлөвшлийг дэмжих, нийгмийн болон хувь хүний хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Хоёр. Үйл ажиллагааны зорилго, зарчим

2.1."Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагаа"-нь суралцагч, багш, ажилтан бүрийн оролцоо, зөв хандлага, ёс зүй, харилцан хүндлэл, итгэлцэл, дэмжлэгт суурилсан хамтын ажиллагаа, суралцах эерэг орчин бүрдүүлэхэд чиглэсэн олон талт, хүртээмжтэй арга хэмжээ зохион байгуулж, хүүхдийн сайн сайхан байдлыг сайжруулах зорилготой.

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээ

3.1."Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагаа"-г төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль бүр өөрийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.Энэхүү удирдамжид заасан үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хамтран 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн 3 үе шаттай хэрэгжүүлнэ:

3.2.1.нэгдүгээр үе шат: 2025 оны 09 дүгээр сар: сургуулийн соёл, суралцагчийн төлөвшлийн хэрэгцээ, төлөв байдлын үнэлгээнд суурилан "Сургуулийн соёл, суралцагчийн төлөвшил" хөтөлбөр боловсруулах, мэдээлэл түгээх;

3.2.2.хоёрдугаар үе шат: 2025 оны 10 дугаар сараас 2026 оны 05 дугаар сар: талуудын оролцоог хангасан арга хэмжээ/хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.3.гуравдугаар үе шат: 2026 оны 05 дугаар сараас 06 дугаар сар: үр дүнг үнэлэх, сайжруулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Сургуулийн үнэт зүйл, эерэг дадал, соёл төлөвшүүлэх хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1.сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч болон бусад дэмжигч талуудын идэвхтэй оролцоотой тодорхойлж баталгаажуулах;

4.1.2.суралцагч, багш, ажилтны оролцоо, хамтын шийдвэр гаргалтын зарчмаар боловсруулж, хүлээн зөвшөөрсөн нийтээр хэрэгжүүлэх сургуулийн дадал, зан үйлийн дүрэм, ёс суртахууны хэм хэмжээг мөрдүүлэх, хэрэгжилтийн явцыг тогтмол үнэлж, шинжилгээ хийх, ил тод, нээлттэй хэлэлцэх тогтолцоо бүрдүүлэх;

4.1.3."Бидний үнэт зүйлс", "Эерэг хандлагатай сургууль", "Сургуулийн соёлын өдөр", "Сургуулийн бахархалт өдөр" зэрэг хамтын соёл төлөвшүүлэх хөтөлбөр/арга хэмжээ зохион байгуулах;

4.1.4.сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, нийтээр хэрэгжүүлэх сургуулийн дадлыг оролцогч талуудад таниулах, сурталчлах, суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчийн хооронд эерэг харилцаа, зөв хандлага, хамтын ажиллагааг дэмжих;

4.1.5.сургуулийн үнэт зүйлсийг хичээл, сургалтын үйл ажиллагаа болон өдөр тутмын харилцаанд хэвшүүлэх, үнэт зүйлсийг үлгэрлэн хэрэгжүүлж байгаа эерэг манлайлалтай суралцагч, багш, ажилтныг алдаршуулан сурталчилж, сургуулийн хамт олны дунд эерэг хандлага түгээн дэлгэрүүлэх.

4.2. Сургуулийн хамт олны эерэг харилцаа, хандлага дэмжих хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. “Хүндлэл ба эерэг харилцаа”, “Харилцан хүндлэл, найрсаг харилцаа”, “Талархал”, “Уучлаарай” гэх зэрэг долоо хоног, сарын аяны хүрээнд суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчийг хамарсан сургалт, хэлэлцүүлэг, хөгжөөнт тоглоом, сайн дурын болон бүтээлч санаачилгын үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.2. суралцагч, багш, ажилтан, удирдах ажилтан, эцэг эх, асран хамгаалагч зэрэг боловсролын харилцаанд оролцогч талуудын өөр хоорондын эерэг харилцаа, үр дүнтэй хамтын ажиллагааны соёл бүрэлдүүлэх, багт нэгдэн ажиллах нөхцөл бүрдүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлж, харилцан хүндлэл, ойлголцлыг дэмжих;

4.2.3. сургуулийн орчин дахь эерэг харилцаа, хамтын ажиллагааг урамшуулах тогтолцоо бүрдүүлж, “Эерэг хандлагатай анги, хамт олон”, “Үлгэр жишээ бахархалт суралцагч”, “Сайн үйлсийн эзэн” зэрэг урамшууллын арга хэмжээ зохион байгуулах;

4.2.4. анги бүлэг бүрд “Ёс зүйн дэд зөвлөл”, “Сэтгэл зүйн зөвлөл” зэрэг сайн дурын клуб, бүлэг байгуулж, тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан эерэг нөлөө бүхий орчин бүрдүүлэх, хамтын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, харилцааны зөрчил, асуудлыг тайван, бүтээлч аргаар шийдвэрлэхийг дэмжих.

4.3. Суралцагчийн төлөвшлийг дэмжих хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. эерэг харилцаа, хүндлэл, хариуцлагын асуудлаар суралцагч, багш нарын дунд Ёс зүйн сургалт, хэлэлцүүлэг, мэтгэлцээн (кейс, цахим орчин дахь төлөвшил, цахим ёс зүй гэх мэт) зохион байгуулах;

4.3.2. суралцагчид өөр хоорондоо хамтран ажиллах, бусдаас суралцах, өөрт тохирсон дэмжлэг авах “Үе тэнгийнхний дэмжлэгийн бүлэг”-ийг үүсгэн, багт нэгдэн ажиллах нөхцөл бүрдүүлэх, хамтран суралцах үйл ажиллагаа идэвхжүүлэх;

4.3.3. суралцагчийн оролцооны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх (“Сайн үйлсийн хөдөлгөөн”, “Эрүүл мэндээ хамгаалах 7 хоног” гэх мэт), суралцагчийн үүсгэл санаачилгын сайн дурын клуб, бүлэг, багийн ажиллагааг дэмжих;

4.3.4. суралцагчдад нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх итгэлцлийн орчин бүрдүүлэх;

4.3.5. суралцагчид өөрийгөө илэрхийлэх, шийдвэр гаргах, бусдыг манлайлах зэрэг хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;

4.3.6. суралцагчийн зөвлөлийг чадавхжуулах, тэдний санаачилсан төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэх.

4.3.7. зөв, эерэг дадал төлөвшүүлэх нийтээр хэрэгжүүлэх сургуулийн дадлаа үйл ажиллагаа бүртээ даган мөрдөх орчин, нөхцөл бүрдүүлэх.

4.4. Суралцагчийн төлөвшилд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. өсвөр насны хүүхдийн онцлог, сэтгэл зүй, цахим хэрэглээ, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга барил зэрэг сэдвийн хүрээнд “Хүүхэдтэйгээ харилцах ухаан” цуврал сургалт, зөвлөгөө, мэдээлэл түгээх;

4.4.2. эцэг, эх, суралцагч, багшийн хамтын ажиллагааг сайжруулах зорилтот “Нээлттэй анги” багш, эцэг эх, суралцагчийн хамтарсан үнэлгээ, харилцан зөвшилцөх арга хэмжээ зохион байгуулах;

4.4.3.эцэг, эх, асран хамгаалагчийн зөвлөлийг чадавхжуулж, багт нэгдэн ажиллах нөхцөл бүрдүүлэх, тэдний оролцоог хүүхдийн төлөвшил, сургуулийн хөгжилд чиглэсэн төлөвлөгөөт, хүртээмжтэй арга хэмжээ зохион байгуулахад чиглүүлэх;

4.4.4.эцэг, эх, асран хамгаалагч, суралцагч, багшийн хамтын ажиллагааг бэхжүүлэх “Мэргэжлээ танилцуулъя өдөрлөг”, подкаст (суралцагчийн хөгжил, сэтгэл зүй, харилцаа гэх мэт), чөлөөт уулзалт, туршлага солилцох өдөрлөг, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах;

4.4.5.гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор олон талт шинэлэг арга хэмжээг санаачлан зохион байгуулах.

4.5.Энэ удирдамжид хавсаргасан тогтмол ажлын төлөвлөгөөний хувилбарыг сургуулийн онцлог, суралцагчийн хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлж болно. /Хавсралт үзнэ үү./

Тав. Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

5.1.Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний хэмжээнд Боловсролын ерөнхий газар нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

5.2.Аймаг, нийслэлийн боловсролын газар нь энэ удирдамжийн дагуу орон нутгийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт хийж, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусална.

5.3. Энэ удирдамжийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль нь суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотой сар бүрийг тусгай зорилготойгоор сургуулийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн, үр дүнтэй зохион байгуулж, гарч буй өөрчлөлтийг улирал бүр хянаж ажиллана.

5.4.Ерөнхий боловсролын сургууль нь “Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагаа”-ны биелэлтийг хичээлийн жилийн эцэст үнэлж, хэлэлцсэний үндсэн дээр дараагийн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөлтийн үндэслэл болгон төлөвлөнө.

5.4.Боловсролын ерөнхий газар нь үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар бусад хамтрагч байгууллагуудад хуваалцах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж, тайланг нэгтгэж, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

Зургаа. Үнэлгээ

6.1.Энэ удирдамжид заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг доор дурдсан нотлох баримтад үндэслэн үнэлнэ:

6.1.1.суралцагчийн зан төлөв, харилцаа, хамтын ажиллагаанд гарсан ахиц, өөрчлөлтийн судалгаа;

6.1.2.суралцагчдын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, уулзалтын тэмдэглэл;

6.1.3.эцэг эх, асран хамгаалагч болон багш, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа;

6.1.4.хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүнг нэгтгэн дүгнэсэн тайлан;

Долоо. Хүрэх үр дүн

7.1.Энэхүү удирдамжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1.сургуулийн үнэт зүйлс болон нийтээр хэрэгжүүлэх дадал, соёл бүрэлдсэн байна;

7.1.2.сургуулийн суралцагч, багш, ажилтны харилцаа болон үйл ажиллагаанд таатай, эерэг уур амьсгал бүрэлдсэн байна;

7.1.3.суралцагчийн зан төлөв, харилцаа хандлагад эерэг өөрчлөлтүүд гарсан байна;

7.1.4.суралцагчийн төлөвшилд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирсан байна.

---000---

**СУРГУУЛИЙН СОЁЛ, СУРАЛЦАГЧИЙН ТӨЛӨВШЛИЙГ ДЭМЖИХ
ТОГТМОЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУВИЛБАР**

№	Чиглэл, үйл ажиллагаа
Нэг. Өдөр тутмын ажил	
Мэндчилгээ ба харилцааны соёл	
1.1.	Багш, ажилтан суралцагчаа угтан мэндчлэх
	"Баярлалаа", "Уучлаарай" зэрэг харилцааны соёл, хүндэтгэлийг илэрхийлэх үгс хэрэглэж хэвших
	Ахлах ангийн суралцагчид бага ангийн дүү нартайгаа мэндлэх, хүндлэх, туслах, дэмжих
Орчны соёл	
1.2.	Сургуулийн орчинд цэвэр цэмцгэр байж, эрүүл орчныг өөрсдөө бий болгох
	Хог хаягдлыг ангилан хаях дадал, хэвшил олгох
	Эд хөрөнгө, хичээл, сургалтад ашиглах багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэхээс хамгаалах, өөриймсөг хандах
Сурах арга барил	
1.3	Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 10 минутын өмнө анги танхимдаа ирсэн байх, хичээлийн эхний цагийн хоцролтгүй дадал хэвшүүлэх
	Хичээл эхлэхийн өмнө 5 минут ном уншдаг дадал хэвшүүлэх
	Суралцагчийн зорилгын дэвтэр хөтлүүлэх
Хоёр. Долоо хоног тутмын ажил	
2.1.	Анги хамт олны хэрэгжүүлэх үйл ажиллагаа
	Долоо хоног бүр ёс зүйн сэдвээр 15-20 минутын ярилцлага зохион байгуулах
	Баасан гарагт долоо хоногийн үйл ажиллагааны дүгнэлт хийх
Дугуйлан, клубын үйл ажиллагаа	
2.2.	Урлагийн дугуйлан, спортын секцийг - Долоо хоногт 1-2 удаа хичээллэх
	Суралцагчийн идэвх санаачилгыг дэмжих, сайн дурын клуб – Долоо хоногт 1-2 удаа уулзалт зохион байгуулах
	Уран зохиол, номын клуб-Долоо хоногт 1 удаа уулзалт зохион байгуулах
	Шинжлэх ухаан, технологийн дугуйлан-Тогтмол туршилт, судалгаа хийх
Эрүүл мэнд, аюулгүй байдлын үйл ажиллагаа	
2.3.	Сургуулийн хэмжээнд тогтмол цагт нийтийн дасгал хөдөлгөөн зохион байгуулах
	Эрүүл мэнд, аюулгүй байдлын сэдвээр тогтмол цагт мэдээлэл, зөвлөгөө өгөх
	Жил бүр суралцагчдын шүд, нүдний эрүүл мэндийн үзлэг зохион байгуулж, эрүүлжүүлэх үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран зохион байгуулах
	Гар, шүд угаах дадал хэвшүүлэх
Гурав. Сар тутмын ажил	
Сургуулийн нийтийн арга хэмжээ	
3.1	Сар бүрийн I долоо хоногт суралцагчдын шинэ бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулах
	Сар бүрийн II долоо хоногт уншсан номын хэлэлцүүлэг зохион байгуулах
	Сар бүр анги, бүлэг хооронд эерэг уур амьсгал, хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах
Ажил, мэргэжил танилцуулах үйл ажиллагаа	

3.2.	Сар бүр ажил, мэргэжил бүрийн төлөөлөл (сургууль төгссөн ах эгч нар г.м)-ийг урьж танилцуулга, ярилцлага зохион байгуулах
	Албан байгууллагад зочилж, ажлын орчинтой танилцах
	Ахлах ангийн суралцагчдад сар бүр ажил, мэргэжил сонголтын зөвлөгөө өгөх
Нийгмийн үйлчилгээ, сайн дурын ажил	
3.3.	Сайн үйлсийн аян, сайн дурын олон талт арга хэмжээг зохион байгуулах
	Ахмад настануудтай уулзаж ажил амьдралын туршлага судлах
	Мод тарих, орчин тойрноо цэвэрлэх гэх мэт үйл ажиллагаа зохион байгуулах
Дөрөв. Улирал тутмын ажил	
Урлаг, спортын арга хэмжээ	
4.1	Урлаг, спортын өдөрлөг, уралдаан тэмцээнийг суралцагч бүрийн тэгш оролцоог хангаж зохион байгуулах
	Улирал бүр эрүүл амьдралын хэв маягийг дэмжих аян зохион байгуулах
Судалгаа шинжилгээний ажил	
4.2	Жил бүр суралцагчдын дунд төсөлт ажлын, судалгааны болон хурал, илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулах
	Суралцагчийн санаачилж, хэрэгжүүлсэн төслийн хэлэлцүүлэг, тайлан хамгаалалт зохион байгуулах
	Шинэ санаа, бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулах
Тав. Хагас жил, жил тутмын ажил	
Амжилтын баяр	
5.1	Амжилтын баяр тайлан, хэлэлцүүлэг зохион байгуулах
	Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үр дүнг харуулсан үзэсгэлэн, өдөрлөг зохион байгуулах
Зургаа. Тогтмол хэрэгжүүлэх хөтөлбөр	
Суралцагчийн зөвлөлийн үйл ажиллагаа	
6.1	Суралцагчийн зөвлөл долоо хоног бүр хуралдаж, үйл ажиллагаа төлөвлөх
	Суралцагчийн дунд тогтмол судалгаа хийж, санал хүсэлтийг шийдвэрлэх
	Хийсэн ажлын тайланг сургуулийн удирдлагад тогтмол танилцуулах
Хүүхэд хамгааллын хөтөлбөр	
6.2.	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг шаардлагатай суралцагчдад үзүүлэх
	Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийг илрүүлж, шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх
	Сургуулийн орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах
Эцэг эх, асран хамгаалагчийн оролцооны хөтөлбөр	
6.3.	Эцэг эх, асран хамгаалагчтэй тогтмол уулзалт зохион байгуулах
	Эцэг эх, асран хамгаалагчид гэрийн даалгавар, хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл, аюулгүй байдлыг хангах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх
Долоо. Сургуулийн төлөвшлийн үнэлгээ	
Тогтмол үнэлгээ	
7.1	Сар бүр суралцагчийн төлөвшлийн ахиц өөрчлөлтийг үнэлэх
	Сургууль дээр нийтээр даган мөрдөх дадал, эерэг зан төлөв, харилцаагаа суралцагч өөртөө “өөрийн үнэлгээ” хийх
	Сургуулийн дадал, соёл төлөвшлийн гарааны үнэлгээ, явц, жилийн эцсийн харьцуулсан үнэлгээ хийх, дүгнэлт, сайжруулалт хийх
	Улирал бүр сургуулийн соёл, төлөвшлийн өөрчлөлтийг үнэлэх
	Жилийн эцэст нэгдсэн дүн шинжилгээ хийх
7.2	Багш суралцагчийн зан төлөв, харилцааг ажиглаж тэмдэглэл хөтлөх
	Суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлтэд үндэслэн сайжруулалт хийх

	Суралцагчтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулж, зөвлөн туслах
Мэдээлэл солилцоо	
7.3	Суралцагчдын дунд хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, тэдний санал, хүсэлтийг сонсож, сайжруулах ажлын чиглэлээ тодорхойлох
	Сар бүр багш нарын хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, сайжруулах ажлын чиглэлээ тодорхойлох
	Эцэг эх, асран хамгаалагчтай суралцагчийн төлөвшлийн талаар мэдээлэл солилцох
	Амжилттай хэрэгжиж буй сайн туршлагыг бусад сургуулийн багштай хуваалцах

---000---